ПРЕМИУМ НЭКСУС ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 04 сарын 28 өдөр Дугаар 1 Улаанбаатар хот

Премиум Нэксус ХК (“**Компани**”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (“**Хурал**”)-ыг 2026 оны 04-р сарын 28-ны өдрийн 10:00 цагт Монгол Улс, Улаанбаатар 14241, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж 19А, Шангри-Ла зочид буудал, 1-р давхар, Шанхай өрөөнд биечлэн хуралдуулав.

Хурлын даргаар Компанийн Гүйцэтгэх захирал Г.Чинзориг, Тооллогын комиссоор Голомт Капитал ҮЦК ХХК- Шинжээч Г.Эрдэнэбаясгалан (дарга), Брокер А.Чинзориг, Брокер Т.Алтангэрэл нар, Хурал зохион байгуулах комиссоор Санхүүгийн газрын захирал, Бизнес контроллер Д.Бүдханд (дарга), Маркетингийн газрын захирал М.Отгонтунгалаг, Төлөөлөн удирдах зөвлөл (“**ТУЗ**”)-ийн нарийн бичгийн дарга Т.Гантулга нар ажиллав.

Хурал зохион байгуулах комиссын дарга Хурлын танхимын онцгой байдлын үеийн аврах гарц, цугларах цэгийн талаар зааварчилгаа өгөв.

Хурлын дарга Тооллогын комиссын даргаас хурлын ирцийг танилцуулахыг хүсэв. Хуралд Компанийн 995,658,077 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг хувьцаа эзэмшигчид оролцож Компанийн нийт саналын эрх бүхий 1,114,252,034 ширхэг энгийн хувьцааны 89.36 хувь болж байгааг Хуралд оролцогч хувьцаа эзэмшигчдэд болон Хурлын даргад танилцуулснаар Компанийн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 89.36 хувийг эзэмшигчид Хуралд оролцож байгаа тул Хурлыг хүчин төгөлдөрт тооцсоныг мэдээлэв.

1. ХУРЛЫН НЭЭЛТ

ТУЗ-ийн (хараат бус) дарга Гари Биондо 2025 онд хамтдаа гаргасан ахиц дэвшлээ дүгнэн хуваалцах боломж олдож буйд баяртай байгаагаа илэрхийлээд Хурлыг нээж, үг хэлэв. 2025 он Компанийн хувьд чухал жил байсан бөгөөд зөвхөн бизнесийн өсөлтөө үргэлжлүүлээд зогсохгүй, илүү сахилга баттай, зорьсон чиглэлтэйгээр хөгжсөн он байв. Компани нь үйл ажиллагаагаа үр ашигтайгаар тэлэхийн зэрэгцээ ил тод, хариуцлагатай засаглал бүхий нээлттэй компанийн суурийг улам бэхжүүлэхэд анхааран ажилласан бөгөөд тайлант хугацаанд олон чиглэлд бодит ахиц гаргасан байна.

Түүнчлэн Компанийн үйл ажиллагааны үр ашиг сайжирч, ханган нийлүүлэлтийн сүлжээ бэхжин, зах зээл дэх байр сууриа илүү зохион байгуулалттай, тогтвортой байдлаар тэлж чадсан бөгөөд эдгээр нь зөвхөн үйл ажиллагааны сайжруулалтаас гадна урт хугацааны илүү бат бөх, тогтвортой үйл ажиллагаа эрхлэх суурийг бүрдүүлж буй чухал алхмууд болсон. Үүний зэрэгцээ компанийн засаглалд онцгой анхаарал хандуулсаар байна. ТУЗ-ийн хувьд бидний үндсэн үүрэг бол хариуцлагатай, шударга байж урт хугацааны үнэ цэнийг хувьцаа эзэмшигч та бүхэд бий болгоход чиглэн ажиллаж буй бөгөөд энэ зарчим цаашид ч Компанийн тэргүүлэх чиглэл хэвээр байх ба Компани нь сахилга баттай өсөлтийг үргэлжлүүлж, үйл ажиллагааны өндөр гүйцэтгэлд төвлөрч, урт хугацаанд тогтвортой үнэ цэнэ бүтээх компанийг цогцлоохоор ажиллах тухай дурдаад Хурал нээснийг мэдэгдэв.

Хурал зохион байгуулах комиссын дарга Хурлын дэг, Хурлаар танилцуулах болон хэлэлцэх асуудлыг танилцуулав. Үүнд:

(i) Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;

(ii) Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах;

(iii) Компанийн 2025 оны санхүүгийн жилийн цэвэр ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэр, түүний шалтгааныг танилцуулах.

Компанийн үйл ажиллагааны талаарх видео бичлэгийг дэлгэцээр гаргав.

2. 2025 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Хурлын дарга, Гүйцэтгэх захирал Г.Чинзориг Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулав.

2021 оны 11-р сард IPO хийснээс хойш жил бүр Хурлаа зохион байгуулж байгааг дурдаад энэ жилийн Хуралд олон хувьцаа эзэмшигчид оролцож байгаад талархал илэрхийлэв. 2025 он Компанийн хувьд чухал жил байсан ба Компанийн үйл ажиллагааг үнэлэн ТОП 100 аж ахуйн нэгжийн 7-р байрт шалгаруулсан. Өнөөдөр СЮ-д 5,100 орчим хүн ажиллаж байгаа ба нийт ажилтнуудын 92.1 хувь нь 30-аас доош насны залуучууд байдаг. СЮ нь залуучуудын ажлын гараагаа эхлэх анхны ажлын байр байдаг тул нэг талаас Компанид залуучуудад ёс зүйтэй бизнес хийх, баг хамт олноороо хэрхэн хамтарч ажиллах зэргээр залуу ажиллах хүчийг төлөвшүүлэх өндөр хариуцлага ирдэг ба СЮ брэндийн нэр хүндийг залуучууд авч явдаг. Үүнийхээ үр дүнд ч Компани нь хүний нөөцийн салбарт Монголын тэргүүлэгч компаниудыг тодруулдаг “Good Workplace Awards - 2025” Best for Youth буюу залуучуудад ээлтэй ажлын байр шагналыг хүртсэн.

Мөн өнөөдөр хүмүүс илүү завгүй болж, хүмүүсийн амьдралын хэв маяг өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор конвиниенс дэлгүүрийн гүйцэтгэж буй нэг чухал үүрэг бол гэр бүлийн цаг завыг хэмнэх, тэр дундаа бэлэн хоолыг илүүтэйгээр зах зээлд нийлүүлэх шаардлага үүсэж байна. Компанийн чухал ач холбогдол өгч ажилладаг стратегийн гол чиглэлүүдийн нэг бол Компанийн хоолны үйлдвэр юм. 2025 онд Компанийн хоолны үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хариуцан эрхэлдэг Сэнтрал Фүүдс ХХК нь Монгол Улсын Шадар Сайдын ивээл дор зохион байгуулагддаг “Үндэсний чанарын чуулган 2025”-д Шилдэг үйлчилгээ категорид тэргүүлэгчээр шалгарлаа. Мөн Компани нь 2025 оны 08-р сард 500 дахь салбар дэлгүүр ээ нээсэн нь Компанийн 2021 оны 11-р сард IPO хийх үеэр 360 дэлгүүр нээхээр өгч байсан амлалтаа биелүүлсэн үйл явдал бөгөөд цаашид ч дэлгүүрийн тоог тэлэх зах зээлийн орон зай байна хэмээн үзэж байгаа тухай танилцуулав.

Компанийн үйл ажиллагаа, үйлчилгээ дэлхийн түвшинтэй харьцуулахад хэр сайн байна вэ гэдгийг 2025 онд үнэлж үзсэн бөгөөд Компани нь Ази-Номхон далайн бүсийн жижиглэн худалдааны салбар дахь шилдэг туршлага, инновацыг үнэлдэг Retail Asia Awards арга хэмжээнээс Монголын зах зээлд конвиниенс дэлгүүрийн соёлыг амжилттай нэвтрүүлснийг цохон тэмдэглэж “Монгол Улс дахь шилдэг сүлжээ дэлгүүр” категорид шилдгээр шалгасан нь Компани үйл ажиллагаа, үйлчилгээндээ дэлхийн стандартыг нэвтрүүлж, нийгмийн хариуцлагатай бодлого явуулсны үр дүн байсан болно.

Компани нь 2021 онд IPO хийхэд Монголын Хөрөнгийн Бирж (“**МХБ**”)-ийн 2-р ангилалд бүртгэгдэж байсан ба Компанийн үйл ажиллагааны цар хүрээ, нийт капитал, үнэлгээний хэмжээ зэргийг авч үзээд 2025 оны 09-р сарын 05-ны өдөр Компанийг МХБ-ийн 1-р ангилалд шилжүүлэн бүртгэсэн нь 2025 оны онцлох үйл явдлуудын нэг болсон.

Компанийн үйл ажиллагааны цар хүрээг харахад Компани нь 2 үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, үүнд СЮ дэлгүүрийн үйл ажиллагаа буюу хүнсний үйлдвэрлэл, жижиглэнгийн худалдаа болон Чингис шар айргийн үйлдвэрлэл, худалдаа, Асахи шар айраг, кофены худалдаа юм. Компанийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж буй удирдлагын бүтцийг харвал 1-д хувьцаа эзэмшигчдийн хурал, 2-д ТУЗ, 3-т менежментийг баг буюу Гүйцэтгэх захирал, Санхүү хариуцсан захирал, Үйл ажиллагаа эрхэлсэн захирал, Портфолио хариуцсан захирал нараас бүрдсэн баг ажиллаж байна.

2025 онд Компани нь шинээр 100 дэлгүүр, үүнээс 53 нь орон нутагт шинээр нээснээр нийт 545 дэлгүүртэй болж өдөрт дунджаар 200 мянган үйлчлүүлэгчид үйлчилсэн. Мөн Компани нь үйл ажиллагаагаа өргөтгөж Монгол Улс даяар 16 аймагт дэлгүүрийн тэлэлтийг хийж өдөр бүр шинэ хоол, хүнсийг түгээж байгаа бөгөөд цаашид баруун бүсийн алслагдсан 5 аймагт үйл ажиллагаа явуулах дэд бүтэц боломжтой нөхцөл байдал бүрдсэний дараа тэдгээр 5 аймагт дэлгүүрийн тэлэлт хийхээр төлөвлөж байна.

Компани нь СЮ аппликэйшн хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлснээр СЮ аппликэйшн хэрэглэгчдийн тоо 1.3 саяд хүрсэн. Энэ нь системийн түвшинд яригддаг банкнуудын аппликэйшн хэрэглэгчдийн тоотой тэнцүү гэсэн үг юм. Компанийн 2025 оны нийт сүлжээний борлуулалт 828 тэрбум төгрөгт хүрсэн буюу 2021 онд IPO хийж байх үеийн 106 тэрбум төгрөгийн борлуулалт жил бүр дунджаар 76 хувиар өссөн бөгөөд Компанийн сүүлийн 6 жилийн хугацаанд дэлгүүрийн тэлэлт 39.5 хувиар, үйлчлүүлэгчдийн тоо 51.6 хувиар, ажиллагсдын тоо 42.6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Компани нь дотоодын аялал жуулчлалыг дэмжих, ажлын байр шинээр бий болгох, татвар хураамжийг төвлөрүүлэхэд төр засагт дэмжлэг үзүүлэх зэрэг өргөн хүрээний ажлыг хийхийн зэрэгцээ үйлчлүүлэгчдэд таатай орчныг бүрдүүлэх, дэлгүүрийн өнгө төрхийг сайжруулахад анхаарч ажилладаг бөгөөд СЮ дэлгүүр нээгдсэнээс хойших 8 жилийн хугацаанд брэндийн үнэ цэнэ, өнгө төрийг алдахгүй, стандартыг барих үүднээс дэлгүүрүүдийн дотоод засвар, шинэчлэлийг хийж, шинээр 100 дэлгүүрийн ариун цэврийн өрөөг засаж сайжруулсан нь хотын өнгө төрх, цэвэр цэмцгэр байдал, үйлчлүүлэгчдийн тав тухтай байдалд чухал хувь нэмэр оруулж байна.

Компанийн чухал дэд бүтэц бол логистикийн бүтэц юм. Компани нь дэлхийн хамгийн үр ашигтай түгээлтийн цогц сүлжээг бий болгон бизнесийн өрсөлдөх чадвараа сайжруулснаар Компанийн борлуулалт өсөж, хүйтэн хэлхээний төвөөр дамжуулан хоолыг түгээснээр үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж сайжирсан. Мөн нэгдсэн түгээлтийн сүлжээгээр дамжуулан дэлгүүрт борлуулагдаж буй нийт бараа бүтээгдэхүүний 99.9 хувийг шөнийн цагаар түгээснээр Улаанбаатар хотын замын түгжрэлийг багасгахад эергээр нөлөөлж байна. 2025 онд Компани нь түгээлтийн бүтээмжээ 10 дахин нэмэгдүүлсэн бөгөөд цаашид ч нэгдсэн түгээлтийн төвдөө нэмэлт хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байна.

СЮ дэлгүүрээр үйлчлүүлэгчдийн 55-60 хувь нь хоол, кофе, уух зүйлс зэрэг бусад үйлчилгээний газраас авах боломжгүй зүйлсийг авахаар зорьж ирдэг. Иймд Компанийн хувьд нэг талаас үйлчлүүлэгчдийн хэрэглээний чиг хандлагад нийцсэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэх, хэрэгцээг хангах, нөгөө талаас үйлчилгээний чанарыг сайжруулах ажлуудыг хийж, 2025 онд дундаж хэмжээнээс илүү их хоол борлуулсан байна. Мөн Компани нь тариалангийн талбайгаас эхлээд хэрэглэгчдийн гарт хүрэх хүртэл дамжлагад хүнсний өртгийг бага байлгах, аюулгүй байдлыг хангахад анхаарч ажилладаг. Тухайлбал Компанийн чухал бүтээгдэхүүнүүдийн нэг болох кофег Солонгос хуурсан үрээр хийдэг байсан бол, өнөөдөр кофены ногоон үрийг өөрсдөө хуурч дээд зэрэглэлийн кофег хийдэг болсноор хэрэглэгчдийн сэтгэл ханамж мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн нь брэндэд үнэнч байдлыг нэмэгдүүлсэн явдал байсан. Мөн Компани нь хүмүүсийн амьдралын хэв маяг өөрчлөгдөхийн хэрээр өөрчлөгдөж буй хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэснээр

үйлчлүүлэгчдийн тоо, үйлчлүүлэх давтамжийг нэмэгдүүлсээр байгаа ба үүний зэрэгцээ дижитал технологийн хөгжлийг байнга дэмжин ажилласны үр дүнд СЮ дэлгүүрээр үйлчлүүлэгчдийн 51 хувь нь СЮ аппликэйшн ашигладаг болсон нь СЮ брэндэд үнэнч хэрэглэгчдийн тоо өсөж байгааг харуулж байна.

Компани нь хүргэлтийн үйлчилгээг дахин сэргээхээр туршилтын ажлыг эхлүүлсэн ба 2026 онд хүргэлтийн үйлчилгээнд нэлээд олон дэвшил гарна гэж найдаж байна. Мөн Сэнтрал Кофе Рөүстинг ХХК нь СЮ дэлгүүрээр борлуулагддаг кофены хэрэгцээг хангахаас гадна дотоодын зах зээлд кофены үрийг нийлүүлэх боломж гарч ирсэн тул цаашид зах зээлд кофены нийлүүлэлтийн гол тоглогч болох зорилго тавин ажиллаж байна.

Түүнчлэн Компанийн хувьд тогтвортой байдал, урт хугацааны үйл ажиллагааны тасралтгүй байдал чухал тул нийгэмд хандсан үйлчилгээ, арга хэмжээгээ улам бүр тэлэхийн тулд Компанийн зүгээс нийгмийн сайн сайханд чиглэсэн үйл ажиллагаагаа өргөжүүлсэн. Компани нь энэ ажлын хүрээнд 2025 онд томоохон хөрөнгө оруулалтууд хийснээс улсын эмнэлгүүдийн ариун цэврийн өгөөг тохижуулахад 1 тэрбум төгрөгийн, багийн спортыг дэмжих зорилгоор Волейболын холбоотой 4 жилийн хугацаанд хамтран ажиллах гэрээг байгуулан 7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр болсон байна. Мөн Цагдаагийн ерөнхий газар (“**ЦЕГ**”)-ын Урьдчилан сэргийлэх хэлтэстэй хамтран “Өдөр бүр анхаарч хайрлая” буюу 365 аяныг эхлүүлж өсвөр үеийнхнийг хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, түүний сөрөг нөлөөг таниулан сурталчлах ажилд идэвхтэй оролцож байгаа бөгөөд 2021 оноос эхлэн “CU чамд тусалъя” уриатай ICU хүүхэд хамгааллын төслийг амжилттай хэрэгжүүлсээр, 2025 оны 05-р сараас эхлэн хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэн СЮ аппликэйшнийг ЦЕГ-ын 102 аппликэйшнтай холбож төөрсөн, сураггүй алга болсон хүүхдийн мэдээллийг CU дэлгүүрийн бүх салбарын POS дэлгэцээр олон нийтэд шуурхай мэдээлэх ажлуудыг зохион байгуулж байна.

Кэй Пи Эм Жи Аудит ХХК-ийн Аудит партнер Сан-Ён Чо ахлагчтай баг Компанийн болон түүний охин компаниуд болох Сэнтрал Фүүдс ХХК, Сэнтрал Коммерс ХХК, Премиум Юнайтед ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд бүрэн хэмжээний аудит хийн аудитын ажлын үр дүнг танилцуулав. Кэй Пи Эм Жи Аудит ХХК нь дэлхийн тэргүүлэгч нягтлан бодох бүртгэлийн фирмүүдийн нэг бөгөөд Аудит партнер Сан-Ён Чо нь Солонгосын худалдааны салбар ялангуяа жижиглэнгийн худалдааны салбарын томоохон компаниудад аудит хийж байсан өндөр туршлагатай. Кэй Пи Эм Жи Аудит ХХК-ийн аудитын ажлын зорилт нь оролцогч талуудын Компанид итгэх итгэлийг хадгалж, цаашид бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах байсан ба Компанийн нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайланд хязгаарлалтгүй буюу цэвэр дүгнэлт гаргасан тухай танилцуулав.

Компанийн нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын хүрээнд аудитын ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна. Мөн Кэй Пи Эм Жи Аудит ХХК-ийн олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохих үндэслэл болох ба Кэй Пи Эм Жи Аудит ХХК-ийн аудитын баг олон улсын дүрэм болон Монгол Улсын ёс зүйн зохих шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн тухай танилцуулав. Кэй Пи Эм Жи Аудит ХХК нь борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлт болон удирдлагын хяналтыг хэрэгжүүлэхгүй байх эрсдэлийн тестэд гол анхаарал хандуулан ажилласан бөгөөд ийнхүү гүйцэтгэсэн аудитын горимууд дээр үндэслэн борлуулалтын орлого үнэн зөв илэрхийлэгдсэн хэмээн дүгнэсэн байна.

2025 оны санхүүгийн үр дүнгийн тайланг Санхүү хариуцсан захирал Г.Бат-Эрдэнэ танилцуулсан бөгөөд Компанийн хөндлөнгийн аудитортой холбоотой товч мэдээллийг өгөв. Компани нь байгуулагдсан цагаас хойш олон улсын “Big 4” буюу дэлхий дээрх 4 том аудитын компаниар аудит хийлгэж ирсэн нь дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдын гол шалгуур болох Компанийн

нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагнал үнэн зөв эсэх, эрсдэл байгаа эсэхийг үнэлж баталгаажуулан харснаар Компанид итгэх итгэл үнэмшлийг бататгадагт оршдог.

Компанийн 2025 оны нийт борлуулалтын орлого 796.4 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 33 хувиар өссөн нь СЮ дэлгүүрийн тэлэлт болон нэгж дэлгүүрийн борлуулалтын өсөлттэй холбоотой байсан ба нийт борлуулсан бүтээгдэхүүний 92.4 хувийг жижиглэнгийн худалдаа эзэлж байсан байна. Компанийн нийт цэвэр ашиг 27.2 тэрбум төгрөг, үүний 75 хувь жижиглэн худалдааны үйл ажиллагаанаас олсон орлого байсан байна. Нийт хөрөнгө 438.3 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 48 хувиар өссөн. Компанийн 2025 оны үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ 71.9 тэрбум төгрөг, хөрөнгийн өгөөж 6.2 хувь буюу өмнөх оны мөн үеэс буурсан харагдаж байгаа нь Компани 2024 онд Чингис Шар Айраг ХХК-ийн хувьцааг худалдан авсантай холбоотойгоор олсон нэг удаагийн ашиг болон 2025 оны нийт хөрөнгө оруулалтын дүн өссөнтэй холбоотой байна. Компанийн нийт ашгийн маржин 2024 онд 18.5 хувь, 2025 онд 18.6 хувь байгаа нь Компани тогтвортой хөгжиж байгааг харуулж байна. Мөн Компанийн нийт ашиг 147.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 37 тэрбум төгрөгөөр өссөн. Мөн үйл ажиллагааны зардал 2024 онд 29.4 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 55.5 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 26 тэрбум төгрөгөөр өссөн нь гурван төрлийн томоохон зардалтай холбоотой бөгөөд зардлын өсөлт нь мэдээллийн технологи, нягтлан бодох бүртгэл зэрэг мэргэжлийн зөвлөх үйлчилгээг гуравдагч этгээдээс авдаг болсон (32.1 хувь), Чингис Шар Айраг ХХК-ийн хувьцааг худалдан авахтай холбоотой нэг удаагийн менежментийн зөвлөх үйлчилгээний хөлс, ажилтнуудын цалин урамшууллын нэмэгдэл, ажиллагсадтай холбоотой зардлын өсөлт (33 хувь) болон борлуулалт маркетингийн зардлын (21 хувь) өсөлтөөс шалтгаалсан байна. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд зааснаар байгууллага нийгмийн сайн сайхны төлөө үйл ажиллагаа явуулбал татвар төлөх дүнгээс хөнгөлөлт эдэлнэ хэмээн заасны дагуу Компани нь 2025 онд эрүүл мэнд, боловсрол, спортын салбарт томоохон хөрөнгө оруулалтуудыг хийсэн. Компанийн 2025 оны хүү, татвар, элэгдэл, хорогдлын өмнөх ашиг 92.3 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 14 хувиар өсөж сайжирсан. Мөн элэгдлийн зардал өссөн байгаа нь Компани жил бүр томоохон хэмжээний хөрөнгө оруулалтыг хийж байгаатай холбоотой бөгөөд Компани хөрөнгө оруулалтыг банкны санхүүжилтээр хийж байгаатай холбоотойгоор зээлийн хүүгийн зардал өмнөх оноос 22 хувиар өссөн тухай тайлбарлав.

Түүнчлэн 2025 оны цэвэр ашгийн хувьд 27.2 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеийн 47.4 тэрбум төгрөгийн цэвэр ашгийн хэмжээтэй харьцуулахад буурсан мэт харагдаж байгаа хэдийн ч энэ нь Компани 2024 онд Чингис Шар Айраг ХХК-ийн үнэлгээтэй холбоотой 19 тэрбум төгрөгийн нэг удаагийн ашгийг хасаж тооцвол Компанийн 2024 оны цэвэр ашиг 28 тэрбум төгрөг буюу Компани 2025 онд цэвэр ашгийн түвшнээ хадгалсан болохыг харж болно. Компанийн 2025 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн хувьд: нийт хөрөнгө 438.3 тэрбум төгрөг буюу 40 хувиар өссөн, үүний 30 хувийг эргэлтийн хөрөнгө, 70 хувийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байгаа ба эргэлтийн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 38 тэрбум төгрөгөөр өссөн байгаагаас 11 тэрбум төгрөг нь мөнгөн хөрөнгийн өсөлт буюу Компанийн данс дахь мөнгөн хөрөнгө, 4 тэрбум төгрөг нь авлага байгаа ба бусад өсөлт нь үйл ажиллагааны тэлэлттэй холбоотойгоор бараа материалын өсөлтөөс шалтгаалсан байна. Эргэлтийн бус хөрөнгө нийт 86.8 тэрбум төгрөгөөр өссөн, үүнээс биет хөрөнгө 71.9 тэрбум төгрөгөөр, ашиглах эрхтэй хөрөнгө 18.5 тэрбум төгрөгөөр өссөн Компанийн хөрөнгө оруулалт, дэлгүүрийн тэлэлт, дэлгүүр, агуулахын түрээс өссөнтэй холбоотой байна. Компанийн 2025 оны нийт өр төлбөр 324 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 110 тэрбум төгрөгөөр буюу 35 хувиар нэмэгдсэн, үүний 16 тэрбум төгрөг нь борлуулалтын цар хүрээ нэмэгдсэнтэй холбоотой дансны өглөгийн өсөлт, урт болон богино хугацаат зээл 71.5 тэрбум төгрөг, үлдсэн хэсэг нь ашиглах эрхтэй хөрөнгөтэй холбоотой өр төлбөр байна.

Компанийн мөнгөн хөрөнгийн тайлангийн хувьд 2025 онд 71.8 тэрбум төгрөгийг үйл ажиллагаанаас сулласан бөгөөд энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32 хувийн өсөлттэй байсан байна.

Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээний хувьд 2025 онд 93 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 85 хувь нь СЮ дэлгүүрийн худалдаа болон тэлэлт, 15 хувь нь Чингис пивоны шинэ үйлдвэрийн хөрөнгө оруулалттай холбоотой байна. Санхүүжилтийн мөнгөн гүйлгээний хувьд мөнгөн орлогын дүн 584.6 тэрбум төгрөг, мөнгөн зарлагын дүн 552.4 тэрбум төгрөг гэх мэт өндөр дүн гарсан байгаа нь Компани санхүүжилтийн шугамыг ашиглаад эргэн төлж, дахин санхүүжилт авч эргэн төлөөд явдаг тул энэ дүн өндөр харагддаг, үүнийг цэвэр түнгээр тайлбарлавал тайлант хугацаанд Компани нь 79 тэрбум төгрөгийн зээл авч, 6.2 тэрбум төгрөгөөр зээлийн шугамыг нэмэгдүүлж, 14 тэрбум төгрөгийн зээлийг эргэн төлж, түрээсийн төлбөрт 29.5 тэрбум төгрөг, хувьцаа эргүүлэн худалдан авахтай холбоотой 17.7 тэрбум төгрөгийг тус тус төлсөн бөгөөд 2025 онд цэвэр мөнгөн урсгалаар нийт 11.3 тэрбум төгрөгийг сулласан байна.

Компанийн 2025 оны өмчийн өөрчлөлтийн тайлангийн хувьд Компанийн нэгдмэл сонирхолтой хувьцаа эзэмшигчдийн хувьцааны эзэмшил 75 хувиас дээш гарсан тул 2025 оны сүүлээр Компани хувьцаагаа эргүүлэн худалдан авах шаардах эрхийг хэрэгжүүлсэн бөгөөд Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 2.7 хувийг 17.7 тэрбум төгрөгөөр худалдан авсан. Компанийн хувьцааны ханшийн хувьд 2025 оны турш нэгж хувьцаа 200-220 төгрөгийн хооронд хэлбэлзэж байсан ба Компани хувьцаагаа эргүүлэн худалдан авсантай холбоотой хувьцааны нэгж үнэ өсөж 317 төгрөгт хүрснээр 2025 оны жилийн эцсээр хаагдсан. 2025 онд Компанийн хувьцааны үнэлгээ 353.2 тэрбум төгрөг, хувьцааны эргэлт 23 тэрбум төгрөг буюу МХБ дээр арилжаалагдсан нийт хувьцааны 8.1 хувь байсан тухай танилцуулав.

Хуралд зохион байгуулах комиссын дарга асуулт хариултын цагийг эхлүүлсэн бөгөөд хувьцаа эзэмшигчдийн зүгээс аливаа асуулт байхгүй байсан тул дараагийн асуудалд шилжив.

3. КОМПАНИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТИЙГ БАТЛАХ

ТУЗ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 болон Компанийн Дүрмийн 9.4.9-р заалтыг тус тус үндэслэн Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дараах дүгнэлтийг гаргаж, хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулав. Компани нь 2025 онд 100 салбар дэлгүүрийг нээж, мэдээлэл технологийн системээ сайжруулж, түгээлтийн дэд бүтцээ олон улсын стандартын шаардлагад нийцүүлж нийт бүтээгдэхүүнийхээ 99 хувийг өөрийн түгээлтийн сүлжээгээр дамжуулан хэрэглэгчдэд очих эцсийн цэг хүртэлх үйлчилгээний чанарыг дэлхийн жишигт хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн бөгөөд 16 аймагт 102 салбар дэлгүүр ажиллуулж, хүнсний хангамж, ариун цэврийн өрөөний хүртээмжийг нэмэгдүүлж, шинэ ажлын байр бий болгосноор дотоодын аялал жуучлалд чухал нөлөө үзүүлсэн.

Мөн бизнесийн дэд бүтцээ өргөтгөн тэлж, үйл ажиллагааны стандарт, хүний нөөцийн чадавхыг сайжруулснаар урт хугацааны өрсөлдөх чадвараа улам бүр бэхжүүлсэн бөгөөд үйл ажиллагааны бүх шатанд байгаль орчин, нийгэм, засаглалын суурь үнэлгээг хийлгэж НҮБ-ын тогтвортой хөгжлийн 17 зорилтыг биелүүлэн нийгэмд хувь нэмрээ оруулж байна.

2025 он Компанийн хувьд 796 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого, 27 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны цэвэр ашигтай ажилласан жил байсан бөгөөд Компанийн Гүйцэтгэх удирдлагын баг 2025 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дайчлан ажилласан хэмээн ТУЗ-өөс дүгнэсэн байна.

4. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХГҮЙ ТУХАЙ ТУЗ-ИЙН ШИЙДВЭР, ТҮҮНИЙ ШАЛТГААН

Компанийн тухай хуулийн 47.1 дэх заалтыг үндэслэн ТУЗ нь Компанийн 2025 оны санхүүгийн жилийн цэвэр ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилахгүй байхаар ТУЗ шийдвэрлэснийг хуралд танилцуулав.

5. САНАЛ ХУРААЛТ, ХУРЛААС ГАРАХ ШИЙДВЭР

Хуралд санал өгөх видео зааврыг дэлгэцээр танилцуулав. Хурал зохион байгуулах комиссын дарга санал хураалтыг эхлүүлэв.

Хурал зохион байгуулах комиссын дарга Тооллогын комиссыг Хурлын санал хураалтын дүнг танилцуулахыг хүсэв. Тооллогын комиссын дарга Хурлын санал хураалтын дүнг дараах байдлаар Хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдэд мэдээлэв. Үүнд:

1. **Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах**: зөвшөөрсөн 995,658,049 ширхэг хувьцаа буюу 100 хувь, татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0 хувь, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0 хувь байна.

Хурлын дарга санал хураалтын дүнтэй танилцаад Хурлаас дараах шийдвэрүүд гарсан тухай танилцуулав. Үүнд:

Тогтоол 1: Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах:

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, Премиум Нэксус ХК ("**Компани**")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04-р сарын 28-ны өдрийн ээлжит хурал ("**Хурал**")-ын шийдвэр, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хавсралт ёсоор баталсугай.

6. ХУРЛЫН ХААЛТ

Ийнхүү хэлэлцэх асуудал дууссан тул Хурлын дарга Хуралд цаг гарган хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчид болон Хурал зохион байгуулсан комисст талархал илэрхийлэв. Түүнчлэн Компанийн хувьд цаашид хөрөнгө оруулалт хийх, үнэ цэнийг нэмэгдүүлэх боломж байгаа ба Компани шаардлагатай хөрөнгө оруулалтуудыг хийх боломжууд байгаа, цаашид Компанийн хувьцааны үнэ цэнэ урт хугацаандаа өсөн гэж итгэж байгаагаа илэрхийлээд Хурлыг хаав.

ХУРЛЫН ДАРГА Г.ЧИНЗОРИГ

PREMIUM NEXUS JSC
ПРЕМИУМ НЭКСУС ХК